Завхан аймаг бүрэн дунд сургууль

# Судлагдахуун: Төсөлт ажил
# 5В анги
# Илтгэлийн нэр: Явцын тайлан хамгаалах хичээл

# зорилго

- Өөрсдийн судалгаан дээр тулгуурлан  олж авсан мэдлэгээ боловсруулж тайлагнах

# зорилт

- 1. Цуглуулсан мэдлэгээ боловсруулах , түүндээ дүгнэлт хийх
- 2. Мэдээллээ  бусадтайгаа хуваалцах
- 3. Өөрийн үгээр чөлөөтэй ярьж сурах

# Анги зохион байгуулалт

- Багаар ажиллах

- 1-р баг бохир гар
- 2-р баг  орчны эрүүл ахуй
- 3-р баг нүд чухал эрхтэн
- 4-р баг  шүдээ хэрхэн хамгаалах вэ?

# Хичээлийн явц

***БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА***

- Сэдэлжүүлэлт

1. Зочин багшийг урих ба эрүүл мэнд чухал хэмээх агуулга бүхий дүрийн тоглолт хийх
2. Энэ дүрийн тоглолтоос юуг ойлгож ухаарсан талаар багуудтай ярилцах

***СУРАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА***

- Дүрийн тоглолтоос баг бүр дүгнэлт хийж юуг ойлгож ухаарснаа бусадтайгаа болон багштайгаа хамтран ярилцана
- Эрүүл мэнд эрхэм баян Эрүүл хүн юуг ч бүтээж чадна тиймээс хүн эрүүл мэндээ хамгаалах хэрэгтэй гэсэн дүгнэлтэнд хүрнэ

# Гол хэсэг

***БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА***

- Тайлан хамгаалах дарааллыг тогтоох
- Дарааллын дагуу багийн тайлан хамгаалах хичээлийг эхлүүлэх
- 1-р баг бусад багтаа зөвлөмж гарын авлага өгсөн бол тодорхой хугацаа өгч судлуулах мөн гүйцэтгэх даалгавар өгвөл тодорхой хугацаа өгч хийлгэх
- Олны санаа оломгүй далай ...
- 1-р багийн хийсэн ажил дуусахад ярилцах цаг гаргаж хамтран ярилцана

***СУРАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА***

- Баг бүрээс нэг сурагч гарч газар тэнгэр тоглоом тоглож дарааллаа хаанаас эхлэхийг гаргаж нар мандах ертөнцийн зүгээс эхлэж нар жаргах зүгт байгаа баг төгсгөлд нь тайлангаа тавьна .

# 1-р баг бохир гар



- Багийн ахлагч багаа болон судалсан асуудлынхаа агуулгыг товч танилцуулах
- Хаанаас хэрхэн мэдээлэл цуглуулсан тухайгаа товч танилцуулна
- Өөрсдийнхөө бэлдсэний дагуу тайлангаа тавих
- Бусад багийн санаа бодлыг бичиж тэмдэглэж авах
- Дараагийн ажилдаа тусгах
- Бусад багаас асуух зүйл гарвал түүнд хариулах

# 2-р баг орчны эрүүл ахуй



- ***Багшийн үйл ажиллагаа:***

2-р багийн тайланг эхлүүлэх

Аливаа материал хэрэглэгдэхүүнийг тодорхой цаг өгч судлуулах

Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй бүлээн усаар угаавал хиргүй

Ярилцах

# 2-р баг орчны эрүүл ахуй



- ***Сурагчийн үйл ажиллагаа:***

Өмнөх багийн адил багийн бүрэлдэхүүн болон судалсан асуудлын агуулга хэрхэн яаж мэдээлэл цуглуулсан тухай товч танилцуулах

Бэлтгэж ирсэн тайлангаа бусаддаа үзүүлэх

Асуултанд хариулах

Бусдын санаа бодлыг сонсож өөрсдийн ажилд хэрэгтэй зүйлээ бичиж тэмдэглэж авах

# 3-р баг нүд чухал эрхтэн



- ***Багшийн үйл ажиллагаа:***

Багийн тайлан хамгаалах 3-р багаас гаргасан зөвлөмж , гарын авалга , зурагт үзүүлэн зэрэг хэрэглэгдэхүүнийг бусад багуудаар тодорхой хугацаанд танилцуулах ба судлуулах

Цувж явсан барнаас Цуглаж суусан шаазгай дээр ... Ярилцах

# 3-р баг нүд чухал эрхтэн



- *Сурагчийн үйл ажиллагаа:*

Багаа болон судалсан асуудлын агуулга , хэрхэн яаж судалсан тухайгаа товч ярих

Тайлангаа хамгаалах

Асуултанд хариулах

Бусдынхаа санаа бодлыг сонсох

Хэрэгтэй зүйлээ тэмдэглэж авах

Багуудын дутуу ойлгосон зүйл гарвал тайлбарлаж өгөх



# 4-р баг шүдээ хэрхэн хамгаалах вэ?

- ***Багшийн үйл ажиллагаа:***

Багийн тайлан хамгаалах зөвлөмж гарын авалга байвал тодорхой хугацаа өгч бусад багуудаар судлуулах

Үнэн үг явдалд тустай ……ярилцах



# 4-р баг шүдээ хэрхэн хамгаалах вэ?



# 4-р баг шүдээхэрхэн хамгаалах вэ?



- ***Сурагчийн үйл ажиллагаа:***

Товч танилцуулга хийх
Өөрсдийн бэлтгэсний дагуу тайлангаа хамгаалах
Бусад багийн асуултанд хариулах
Бусад багийнхаа саналыг сонсох
Багийн ажилд хэрэгтэй санал гарвал тэмдэглэж авах
Өөрсдийн ажилдаа тусгах

# ДҮГНЭЛТ

- ***Багшийн үйл ажиллагаа :***

Багуудын ажилд удирдсан багшийн зүгээс дүгнэлт хийх

Цаашид баг бүр аль талаас нь хэрхэн яаж хаанаас судлаж болох тухай зөвлөгөө өгөх

- ***Сурагчийн үйл ажиллагаа:***

Багшийн дүгнэлт болон зөвлөгөөг ажлын дэвтэртээ тэмдэглэж авах

# Гэрийн даалгавар

- ***Багшийн үйл ажиллагаа:***

Цаашид судалгаагаа хэрхэн яаж үргэлжлүүлэн хийх тухай төлөжвлөгөө хийж шалгуулах

- ***Сурагчийн үйл ажиллагаа:***

цаашид хийх ажлын төлөвлөгөөг багшийн зөвлөгөөний дагуу боловсруулаад чөлөөт цагаараа багшид шалгуулах

# Анхаарал тавьсанд баярлалаа